



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 9/215

Зуунмод

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт
ажиллах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 4 дүгээр зүйлийн 4.4, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/120 дугаар тушаалын 4 дүгээр заалт, Улсын онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 26-ны 10 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Шуурхай штабын хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумдад Коронавируст /Ковид-19/ халдвартын цар тахлын тохиолдол батлагдсантай холбогдуулан Монгол улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Түр журам”, Улсын онцгой комиссын хурлын шийдвэрийн дагуу 2021 оны 03 дугаар сарын 28-ны 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд “Бүх нийтийн бэлэн байдал”-ын IV зэрэг буюу “Улаан түвшин”-д шилжин ажилласугай.

2. Бүх нийтийн бэлэн байдлын IV зэрэг буюу “Улаан түвшин”-д шилжсэн хугацаанд нутаг дэвсгэрийн хэмжээнд зөвшөөрөгдсөнөөс бусад төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлаж, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийг тогтоосугай.

3. “Улаан түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг онцгой дэглэм, тусгай шаардлага нөхцөлийн өндөр хяналтан дор халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллуулахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Коронавируст /Ковид-19/ халдвартын цар тахал сумдад батлагдсантай холбогдуулан сумын Эруул мэндийн төвүүд ор нэмэлтээр дэлгэх төлөвлөгөөний дагуу бэлтгэл бэлэн байдлыг хангаж, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодис, эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхэд мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг

аймгийн Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

5. Улаанбаатар хот, бусад аймаг, өөрийн аймгийн сумдаас орон нутагт зорчих хөдөлгөөнийг зөвхөн хүндэтгэн үзэх шалтгаан (Эрүүл мэнд, буяны ажил)-тай иргэд, зайлшгүй шаардлагатай ачаа тээвэр (Хүнс, шатахуун, өвс, тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл, уул уурхай) тээвэрчдийг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд зөвхөн аймгийн онцгой комиссын шийдвэр, халдварт бүртгэгдсэн газраас PCR шинжилгээний хариуг үндэслэн халдварт хамгааллын дэглэмийг хатуу мөрдүүлэн нэвтрүүлж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар), Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг), Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Зайлшгүй шалтгаанаар сумдад ирж байгаа иргэдийг сумын онцгой комиссын шийдвэрээр 7 хоног гэрийн тусгаарлалтад ажиглан, хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

7. “Улаан түвшин”-д шилжсэн хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, түүнд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллахыг Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг), Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

8. Коронавируст /Ковид-19/ халдвартын цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан “Улаан түвшин”-д шилжсэн хугацаанд өрөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоож, энэ хугацаанд сургууль, цэцэрлэгийн анги танхим, дотуур байруудын ариутгал халдвартгүйжүүлэлт хийлгэхийг Боловсрол, соёл урлагийн газар (Р.Ундрахбаяр)-т даалгасугай.

9. Улсын онцгой комиссын баталсан түр журам, тусгай шаардлага нөхцөлийг чанд мөрдүүлж, сум орон нутагтаа шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/158 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч, дарга бөгөөд Онцгой байдлын газрын дарга (Н.Төмөрбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР

